

2025 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 08-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2025-09-08

Өндөртолгой

Үүргийн биелэлтийг Arial-11, 12 фонтоор бичиж, **2025 оны 09 дүгээр сарын 16-ны “Мягмар” гарагт** Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Эрх зүй, хяналт шинжилгээ үнэлгээ, хөрөнгө орлогын мэдүүлэг хариуцсан мэргэжилтэн (ERP Н.Батцэнгэл)-д албан бичгээр болон word файлаар ирүүлнэ үү.

Нийслэл, дүүргийн удирдлагаас цаг үеийн холбогдолтой өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд онцгой анхаарч биелэлтийг ирүүлэхдээ нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам”-ын 8.6 дахь хэсэгт заасан дараах шаардлагын дагуу тайлагнахыг анхаарна уу

8.6.Байгууллагаас ирүүлэх бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, холбогдох тайлан, мэдээ нь дараах шаардлагыг хангасан байна:

- 8.6.1. үйл ажиллагааны гүйцэтгэлийг бүрэн багтаасан, тайлант хугацааг бүрэн хамруулсан байх;
8.6.2. үг үсгийн болон хэл найруулгын хувьд алдаагүй, тоо баримт зөрөөгүй байх;
8.6.5. тайлан дахь хүрсэн түвшний талаарх мэдээллийн үнэн, зөв эсэхийг нягтлан шалгасан байх;
8.6.6. хийсэн ажлыг бүрэн хамруулж, үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийн үндэслэл, шалтгааныг тодорхой гаргасан байх;
8.6.7. хэрэгжилтийг 2000 (хоёр мянган) тэмдэгтэд багтааж, үр дүн, үр нөлөөг тайлагнах;

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГАААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж шилэн дансанд холбогдох мэдээлэл, хавсралт файлыг бүрэн оруулах	Дотоод аудитын алба, Нийт байгууллагууд
2	Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг эрчимжүүлж, давс, бодис нөөцлөх ажлыг шуурхай зохион байгуулах.	ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ,
3	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах	Цагдаагийн хэлтэс
4	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчимд зөвшөөрөлгүй тамхи худалдан борлуулж буй үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж холбогдох журмын дагуу арга хэмжээ авч ажиллах	ТХҮХ, Цагдаагийн хэлтэс, Хүнсний чанар стандартын улсын байцаагч
5	Засгийн газрын 2025 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах тухай” 56 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах	Тамгын газрын дарга Л.Санжийжамц, ТХҮХ
6	Ус хангамж, ариутгах татуургын нэгдсэн сүлжээнд холбогдсон эсэхэд хяналт тавих, техник, технологи, хүний нөөцийн бэлэн байдлыг хангуулах	ТХҮХ, Ус суваг ашиглалтын товчоо
7	Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд зөвшөөрөлгүй хашаа барьсан зөрчлийг арилгах	Газар зохион байгуулалтын алба
8	Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний засвар, шинэчлэлийн ажлын хяналтыг сайжруулж, нөхөн сэргээлтийн ажлын чанар, стандартад хяналт тавих	ТХҮХ, Илч-Орд ОНӨААТҮГ
9	Тарваган тахлын өвчлөл гарсантай холбогдуулан авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоод болон маршрутын бус замаар нэвтэрч буй машин техникийг нэг бүрчлэн шалгах	Цагдаагийн хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Мал эмнэлгийн тасаг
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
10	Шаардлагатай байршлуудад суваг шуудуу татаж, ус зайлуулах хоолой хийх ажлыг эрчимжүүлэх	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
11	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд ихээр үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг тодорхойлж, иргэдэд сэрэмжлүүлэг контент бэлтгэн хүргэх	Цагдаагийн хэлтэс, “Багахангайн Теле камерын хяналтын дэд төв” ОНӨААТҮГ
12	Хороодод хийгдэж буй хөрөнгө оруулалтын ажлуудыг эрчимжүүлэх, санхүүжилтийг шийдвэрлүүлэх	ТХҮХ, 1,2 дугаар хороод
13	Улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй томоохон ажлуудын (хөшигтийн хөндий чиглэлийн салбар төмөр замын дэд бүтцийн ажил гм) холбогдох баримт, лавлагаа мэдээллийг бүрдүүлэх, архивлах	Архивын хэлтэс
14	Замчин, нуурын гэр хорооллын иргэдэд цэвэр, бохир ус, халаалтын шугам хоолой татахад шаардлагатай материал, санхүүгийн тооцооллын талаар мэдээлэл хүргэх, гарын авлага бэлтгэн тараах	ТХҮХ, Илч-Орд ОНӨААТҮГ, Ус суваг ашиглалтын товчоо

15	Ус цэвэршүүлэх төхөөрөмжийн өнөөгийн нөхцөл байдлын талаар танилцуулах	ТХҮХ, Ус суваг ашиглалтын товчоо, ТЗ-ын ЭЧВОД, ТЗ-ын БОС
16	Хойд жигүүрийн халаалтын шугам сүлжээ солих ажлыг эрчимжүүлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангаж ажиллах	ТХҮХ, Илч-Орд ОНӨААТҮГ
17	Хойд жигүүрийн халаалтын шугам солигдож байгаатай холбогдуулан өөрийн байгууллагын салбар шугамын хаалтыг шинэчлэх	Соёлын ордон, 44 дүгээр цэцэрлэг, Дотоод аудитын алба, СӨХ
18	Налайх дүүрэгт зохион байгуулагдах "Mining week" арга хэмжээнд байгууллагын дарга, эрхлэгч, ахлах мэргэжилтнүүд, ЕБС-ийн ахлах ангийн сурагчдыг оролцуулах	Засаг даргын орлогч Х.Цогцэцэг, ТЗУХ, НХХ, ЕБС-ууд, нийт байгууллагууд
19	Дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын татвар төлөлтийн талаар мэдээлэл бэлтгэн танилцуулах	СТСХ, Татварын хэлтэс
20	"Найрамдал -2" төслийг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулах, БНСУ-ын холбогдох байгууллагад хүсэлт хүргүүлэх	Засаг даргын орлогч Х.Цогцэцэг, НХХ
21	"Хөх хотын ОУ-ын Монгол эмнэлэг"-ийн эмч нарыг дүүрэгт 2025 оны 09 сарын 15-16-ны өдрүүдэд ажиллуулах хүсэлтийг Эрүүл мэндийн яаманд хүргүүлэх	НХХ
22	Дүүргийн ААНБ-д өөрийн байгууллагын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын талаар мэдээлэл бэлтгэн иргэдэд хүргэх	Нийт байгууллагууд
23	Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх	ТХҮХ, Онцгой байдлын хэлтэс

---о0о---